



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 558

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 12 нэрийн, нийт 1,491,056,686.51 (нэг тэрбум дөрвөн зуун ерэн нэгэн сая тавин зургаан мянга зургаан зуун наян зургаан төгрөг тавин нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 1,452,089,249.22 (нэг тэрбум дөрвөн зуун тавин хоёр сая наян есөн мянга хоёр зуун дөчин есөн төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг Батлан хамгаалахын яаманд балансаас балансад шилжүүлсүгэй.

2.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий захирал Г.Ёндон, Батлан хамгаалахын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Бригадын генерал Д.Ганхуяг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 08 дүгээр сарын 08-ны өдрийн
558 дугаар тогтоолын хавсралт

**"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМАНД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл үнэ	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа (жил)
1	Цахилгаан хайч механик НГ-13	05.01.2000	1	157,012,000.00	157,012,000.00	-	1,308,433.30	2
	ДҮН-Баяжуулах үйлдвэр		1	157,012,000.00	157,012,000.00	-	1,308,433.30	-
Ган бөмбөлгийн цех								
2	Цахилгаан хөдөлгүүр 5АНК355В4У3 400кВт об/м	31.12.2017	1	35,335,363.44	16,808,283.84	18,527,079.60	-	-
3	Цахилгаан хөдөлгүүр 5АНК355В4У3 400кВт об/м	30.11.2018	1	30,154,794.72	12,333,144.12	17,821,650.60	-	-
	ДҮН-Ган бөмбөлгийн цех		2	65,490,158.16	29,141,427.96	36,348,730.20	-	-
Авто тээврийн цех								
4	Автосамосвал Краз 65055 № 86-14 орх	31.01.2008	1	156,792,134.00	156,792,134.00	-	1,306,601.10	2
5	Автосамосвал Краз 65055-052 № 39-22орх	31.05.2008	1	139,481,735.00	139,481,735.00	-	1,162,347.80	2
6	Автосамосвал Краз 65055-052 № 39-23 орх	31.05.2008	1	139,481,735.00	139,481,735.00	-	1,162,347.80	2
7	Автосамосвал Краз 65055-052 № 39-24орх	31.05.2008	1	139,481,735.00	139,481,735.00	-	1,162,347.80	2
8	Автосамосвал Краз 65055-052 № 39-25орх	31.05.2008	1	139,481,735.00	139,481,735.00	-	1,162,347.80	2
9	Автосамосвал Краз 65055-052 № 39-26орх	31.05.2008	1	139,481,735.00	139,481,735.00	-	1,162,347.80	2
10	Автосамосвал HYUNDA I DUMPHD270 № 60-18орх	31.12.2008	1	198,954,580.35	198,954,580.35	-	1,657,954.80	2
11	Ачааны автомашин HYUNDAIHD120 № 32-09 ОРХ	31.12.2007	1	130,968,720.00	128,350,012.91	2,618,707.09	-	-

ДҮН-Авто тээврийн цех		8	1,184,124,109.35	1,181,505,402.26	2,618,707.09	8,776,294.90	-
Онцгой байдлын хэсэг							
12	Галын машин АЦ-40 №41-98оро	28.02.2006	84,430,419.00	84,430,419.00	-	844,304.20	2
Дүн-Онцгой байдлын хэсэг		1	84,430,419.00	84,430,419.00	-	844,304.20	-
Эрдэнэт сувиллын цогцолбор							
			1,491,056,686.51	1,452,089,249.22	38,967,437.29	10,929,032.40	-
БҮГД ДҮН			(нэг тэрбум дөрвөн зуун ерэн нэгэн сая тавин зургаан мянга зургаан зуун наян зургаан төгрөг тавин нэгэн мөнгө)	(нэг тэрбум дөрвөн зуун тавин хоёр сая наян есөн мянга хоёр зуун дөчин есөн төгрөг хорин хоёр мөнгө)	(гучин найман сая есөн зуун жаран долоон мянга дөрвөн зуун гучин долоон төгрөг хорин есөн мөнгө)	(арван сая есөн зуун хорин есөн мянга гучин хоёр төгрөг дөчин мөнгө)	-